

## **2012 онд хэвлэл мэдээллийн байгууллагуудадтай хамтран ажиллах зар**

Хүн амд эрүүл зан үйл төлөвшүүлэх, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх мэдээлэл сурталчилгааг тасралтгүй, өргөн цар хүрээтэйгээр олон нийтэд хүргэж байж үр дүнг нь хүртэх боломжтой юм. Иймээс хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж хүн амд мэдээ, мэдээлэл, зөвлөгөөг тасралтгүй, бодитой, хүртээмжтэй, үндэсний хэмжээнд түгээж олон нийтэд хүргэх зорилгоор манай байгууллага Эрүүл Мэндийг Дэмжих Сангийн санхүүжилтээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллах гэж байна.

Иймээс ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох , эрүүл зан үйл төлөвшүүлэх мэдээ мэдээлэл түгээх ажилд хамтран ажиллах саналаа ирүүлнэ үү

Энэхүү сонгон шалгаруулалтанд дараах шаардлага хангасан Монгол улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий хэвлэл мэдээллийн хэрэгслүүд: Телевиз, Радио, Сонин, Сэтгүүл, Вэб сайтууд оролцох боломжтой бөгөөд сонгон шалгаруулалтанд оролцох саналаа 2012 оны 3 сарын 05-ны дотор ЗГХА-ЭМГ-ын НЭМХ, ЭМДСангийн ажлын албанд ирүүлнэ үү

Сонгон шалгаруулах техникийн нөхцөл:

ТЕЛЕВИЗ, РАДИО:

- Монгол улсын орон даяар нэвтрүүлгээ цацдаг байх
- Хамтран ажиллах хүрээнд хийгдэх ажлыг гүйцэтгэх мэргэжлийн уран бүтээлчидийн багтай байх
- Эрүүл мэндийн зөвлөгөө мэдээллийн нэвтрүүлэг бэлтгэн үзэгчдэд хүргэдэг туршлагатай байх
- Эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээллийн тогтмол өдөр, цаг, булан ажиллуулах
- Үйл ажиллагаа нь жигдрээд 2 ба түүнээс жил болсон байх
- Өмнөх жилд манай байгууллагатай хамтран ажиллаж гэрээгээ сайн хэрэгжүүлж, зохих үр дүнд хүрсэн бол давуу тал болно.

СОНИН:

- Өдөр тутмын сонин байх ба захиалганд орсон байх
- Эрүүл мэндийн зөвлөгөө мэдээллийн булан бэлтгэн уншигчдад хүргэдэг туршлагатай байх, эрүүл мэндийн мэргэшсэн сэтгүүлч ажиллуулах
- Үйл ажиллагаа нь жигдрээд 2 ба түүнээс жил болсон байх
- Өмнөх жилд манай байгууллагатай хамтран ажиллаж гэрээгээ сайн хэрэгжүүлж, зохих үр дүнд хүрсэн бол давуу тал болно.

СЭТГҮҮЛ, ВЭБ САЙТ:

- Сэтгүүл бол захиалганд орсон байх, Вэб сайт бол байнгын үйл ажиллагаатай буюу мэдээллээ өдөр бүр шинэчилдэг байх

- Мэдээллийг өөрийн боломжит сувгаараа олон нийтэд хүргэх
- Эрүүл мэндийн зөвлөгөө мэдээллийн булан бэлтгэн уншигчдад хүргэдэг туршлагатай байх, эрүүл мэндийн мэргэшсэн сэтгүүлч ажиллуулах
- Үйл ажиллагаа нь жигдрээд 2 ба түүнээс жил болсон байх
- Өмнөх жилд манай байгууллагатай хамтран ажиллаж гэрээгээ сайн хэрэгжүүлж, зохих үр дүнд хүрсэн бол давуу тал болно.

ЗГХА-ЭМГ-ын НЭМХ, ЭМДС-гийн ажлын алба